



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 639

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 8,149,000.03 (найман сая нэг зуун дөчин есөн мянган төгрөг гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг дахин сунгаж, нийт үнийг 7,000,000.00 (долоон сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Политехник коллежид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Т.Намнан, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Политехник коллежийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Сүхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002761
28-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1 дугаар сарын 12-ны өдрийн
833 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
ШУТИС-ИЙН ХАРЬАА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)
1	Самсунг CV-110, 94-64 УБЗ, KNR1L1HEYXT007102	1999/2008	3,173,333.33	3,173,333.33	-	2	3,000,000.00
2	Ниссан Х-трэйл, 77-97 УБЕ, NT30029908	2001/2011	4,975,666.70	4,975,666.70	-	2	4,000,000.00
	НИЙТ ДҮН		8,149,000.03 (найман сая нэг зуун дөчин есөн мянган төгрөг гурван мөнгө)	8,149,000.03 (найман сая нэг зуун дөчин есөн мянган төгрөг гурван мөнгө)	-		7,000,000.00 (долоон сая)